

ДАРХАН-УУЛ АЙМГИЙН СОЁЛ, УРЛАГ, АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛ,
ЗАЛУУЧУУДЫН ГАЗРЫН ХАРЬЯА СОЁЛЫН БАЙГУУЛЛАГУУДЫН
2023 ОНЫ ҮР ДҮНД СУУРИЛСАН НЭМЭЛТ САНХҮҮЖИЛТИЙН
ХЭРЭГЖИЛТ, ҮР ДҮНД ДОТООД ХЯНАЛТ ХИЙСЭН
ДҮНГИЙН ТАНИЛЦУУЛГА

2024 оны 11 сарын 13 өдөр

Дугаар 02

Дархан-Уул аймаг

Нэг. Дотоод хяналтын зорилго, үндэслэл:

Төрийн хяналт шалгалтын тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.3 дахь заалт, Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.6 дахь заалт, Монгол Улсын Засгийн газрын 2011 оны 311 дүгээр тогтоолоор баталсан "Аж ахуйн нэгж, байгууллагын үйл ажиллагаанд дотоод хяналт шалгалтыг зохион байгуулах нийтлэг журам"-ын 3.7 дахь хэсэг, Соёлын сайдын 2021 оны А/43 дугаар тушаалаар баталсан "Дотоод хяналт шалгалт зохион байгуулах журам", 2023 оны А/390 дүгээр тушаалаар баталсан "Соёлын байгууллагуудын үр дүнд суурилсан санхүүжилтийн аргачлал", тус газрын даргын 2024 оны 10 дугаар сарын 18-ны өдөр баталсан 02 дугаартай удирдамжийн дагуу харьяа соёлын 7 байгууллагад 2023 оны үйл ажиллагааны үр дүнгээр олгосон нэмэлт санхүүжилтийн зарцуулалтад дотоод хяналт хийж, холбогдох хууль тогтоомжийн хэрэгжилт, үр дүнг үнэлэх, цаашид үр нөлөөг нэмэгдүүлэх зорилгоор хийж гүйцэтгэсэн.

Хоёр. Дотоод хяналт хийсэн бүрэлдэхүүн, хугацаа:

Батлагдсан удирдамжийн дагуу дотоод хяналтыг тус газрын Захиргаа, удирдлагын хэлтсийн Хяналт-шинжилгээ, үнэлгээ статистик мэдээ хариуцсан мэргэжилтэн, Дотоод хяналт хариуцсан ажилтан Ш.Дэлгэрмаа ахалж, Төсөв, хөрөнгө оруулалтын асуудал хариуцсан ахлах мэргэжилтэн П.Цогцэцэг нарын бүрэлдэхүүнтэй 2024 оны 10 дугаар сарын 28-наас эхлэн 11 дүгээр сарын 05-ны өдрийг хүртэлх хугацаанд соёлын 7 байгууллагын удирдлага, дотоод хяналт хариуцсан ажилтан, ахлах нягтлан бодогч нарыг байлцуулан хийж гүйцэтгэлээ.

Гурав. Дотоод хяналтаар хамрагдсан асуудал:

Тус газрын харьяа Залуучууд театр, Музей, Төв номын сан, Хүүхдийн номын ордон, Орхон, Хонгор, Шарын гол сумдын Соёлын төвд 2023 оны үйл ажиллагааны үр дүнгээр олгосон нэмэлт санхүүжилтийн зарцуулалтад дотоод хяналт хийж,

хэрэгжилт, үр дүнг үнэлж, цаашид үр нөлөөг нэмэгдүүлэх чиглэлээр зөвлөн тусалж, мэргэжил арга зүйн зөвлөгөө өгч, дүгнэлт гаргаж ажиллалаа. Тухайлбал:

3.1. Хөтөлбөр, арга хэмжээ буюу уран бүтээл хийх, эрдэм шинжилгээний судалгааны ажилд зардлын хувь хэмжээг баримтлан зарцуулсан байдал, гарсан үр дүнг;

3.2. Байгууллагын үйл ажиллагааг дэмжих хөрөнгө оруулалтын ажилд зардлын хувь хэмжээг баримтлан зарцуулсан байдал, гарсан үр дүнг;

3.3. Албан хаагчдын нийгмийн асуудлыг шийдвэрлэх арга хэмжээнд зардлын хувь хэмжээг баримтлан зарцуулсан байдал, гарсан үр дүнг;

3.4. Ажилтны ажлын үр дүнг үнэлж урамшуулалд зардлын хувь хэмжээг баримтлан зарцуулсан байдал, гарсан үр дүнг тус тус дүгнэлээ.

Дөрөв. Дотоод аудитын шалгалтад хамрагдсан объектын талаарх товч танилцуулга

4.1. Залуучууд театр нь Монгол улсын мэргэжлийн урлагийн томоохон байгууллагуудын нэг юм. Дархан хотын нийт оршин суугчдын 80 гаруй хувийг 30 хүртэлх насны хүүхэд залуучууд эзэлж байсан болоод залуухан театрын эрч хүчтэй залуу уран бүтээлчдийн туурвин буй уран бүтээлийн урын сангийн бодлого нь хүүхэд залуучуудад хандаж байсныг тэмдэглэн 1978 оны 08 дугаар сарын 02-ны өдрийн МАХН-ын Төв хорооны Улс төрийн товчооны /хуучин нэрээр/ тогтоолоор Дархан хотын "Залуучууд" театр болгож өргөжүүлсэн юм.

4.2. Музей нь МАХН-ын Төв хорооны нарийн бичгийн дарга нарын 1968 оны 12 дугаар сарын 20-ны өдрийн 553 дугаар тогтоолоор Дархан хотын Найрамдал музей, 1994 оноос Дархан-Уул аймгийн Музей болон өргөжсөн. Музей нь соёлын үнэт зүйлсийг бүртгэх, цуглуулах, хадгалж хамгаалах, судлах, сурталчлах, түгээн дэлгэрүүлэх ажлыг бүх нийтэд зориулан соёлын үрийг түгээж байна.

4.3. Төв номын сан нь 1964 онд анхны сууриа тавьж эхэлсэн бөгөөд 15 ажилтантайгаар Дархан-Уул аймагт үйл ажиллагаагаа явуулж байна. Аймгийн иргэд болон хүүхэд залуучуудад соён гэгээрүүлэх, соёлыг түгээн дэлгэрүүлэх, хуучний болон орчин цагийн утга зохиол, яруу найраг бүх төрлийн номыг танхим болон цахим хэлбэрээр мэдлэгийг түгээж соёлын үйлчилгээг

4.4. Хүүхдийн номын ордон нь Дархан-Уул аймгийн эцэг эхчүүдийн анхдугаар зөвлөгөөний санаачилга, Аймгийн Засаг даргын дэмжлэгээр, аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2003 оны 02 дугаар сарын 12-ны өдрийн 17 дугаар тогтоолоор хөдөө орон нутагт анхдагч "Хүүхдийн хөгжлийн төв"-

ийг байгуулж, 2003 оны 05 дугаар сарын 07-ны өдрийн 42 дугаар тогтоолоор "Хүүхдийн Номын Ордон" гэж өөрчилсөн түүхтэй. Байнгын үйл ажиллагаатай уншлага үйлчилгээний 2 танхим, салбар номын сан 1, төрөлжсөн 5 танхимтай, нэг ээлжид 150 уншигч хүлээн авах хүчин чадалтай байсныг 2022-2023 онд өөрсдийн хүч бололцоо, төсөл хөтөлбөрт хамрагдан суудлын тоог 20-25-аар нэмж 175 хүүхэд нэг дор хүлээн авах хүчин чадалтай болон өргөжсөн байна.

4.5. Шарын гол Соёлын төв нь 1965 онд ашиглалтад орж байсан. Соёлын төвийн үндсэн 9 ажилтан, сумын 8200 иргэнд соёл, урлагийн үзвэр, үйлчилгээ үзүүлэхийн зэрэгцээ сурагчдад зориулсан дугуйлан, насанд хүрэгчдэд зориулсан бүжиг, гоо зүйн сургалтууд явуулж, ард иргэдэд соёлыг түгээн дэлгэрүүлэх зорилго зорилт тавин ажиллаж байна.

4.6. Орхон сумын Соёлын төв нь Жимс ногооны САА-н клуб нэртэйгээр 1969 онд үйл ажиллагаагаа эхлүүлж, 1974 онд шинэ байранд нүүж орон Сэлэнгэ аймгаас Дархан хотын мэдэлд шилжин эрхлэгчээр Д.Барамсай, кино механикч, номын санч гэсэн 4 орон тоотойгоор ажиллаж байжээ. 1991 онд 220 хүний суудалтай хурал, спортын танхим бүхий иж бүрэн соёлын төв шинэ барилга ашиглалтанд орсноор Орхон сумын иргэдэд Соёл урлагаар үйлчилж байна.

4.7. Хонгор сумын Соёлын төв нь 1969 онд ЗХУ-ын хөрөнгөөр Монгол Зөвлөлтийн найрамдлын нэрэмжит Дархан сангийн аж ахуйн "Ажилчны клуб" нэртэйгээр анх байгуулагдсан бөгөөд 1982 онд Дархан хотын АДХГЗ-ны даргын шийдвэрээр Хонгор сумын "Соёлын төв" болгон өөрчилж, одоогоор дарга, нягтлан бодогч, номын санч, бүжгийн багш, хөгжмийн багш, музейн ажилтан, үйлчлэгч гэсэн орон тоотой иргэдэд соёл урлагаар үйлчилж байна.

Тав. Өмнөх дотоод хяналт шалгалтын талаар:

ССАЖЗЯ-ны ХШУДАГ-2024/ДА/08 дугаартай удирдамжийн дагуу 2024 оны 04 дүгээр сарын 11-нээс 04 дүгээр сарын 23-ны өдөр хүртэлх хугацаанд харьяа соёлын 7 байгууллагад 2022 оны үйл ажиллагааны үр дүнгээр олгосон нэмэлт санхүүжилтийн зарцуулалтад санхүүгийн болон нийцлийн аудит хийж, хэрэгжилт, үр дүнг үнэлж, цаашид үр нөлөөг нэмэгдүүлэх зорилгоор албан хаагчдаас цахимаар санал авч, зөвлөмж өгч, нэгдсэн дүнгийн танилцуулгыг ССАЖЗЯ-ны ХШУДАГ-т албан бичгээр хүргүүлж, цахимаар илгээж тайлагнасан. Хэрэгжилт 100 хувь

**Зургаа. Дотоод хяналтын явцад хийгдсэн ажил,
шийдвэрлэсэн асуудал:**

6.1. Залуучууд театр нь улсын хэмжээнд 11 дүгээр байранд орж 62,690,175.34 төгрөгийн нэмэлт санхүүжилт авч, доорхи зарцуулалтыг хийсэн байна.

6.1.1 Хөтөлбөр, арга хэмжээ буюу уран бүтээл хийх, эрдэм шинжилгээний судалгааны ажлын зардалд 30% буюу 18,888,100 төгрөгийг уран бүтээл хийхэд зарцуулсан байна. Үүнд:

Тулгар төр байгуулагдсаны 2233 жил, Их Монгол Улс байгуулагдсаны 818 жил, Үндэсний эрх чөлөө, Тусгаар тогтнолоо сэргээн мандуулсны 113 жил, Ардын хувьсгалын 103 жил, Дархан хот байгуулагдсаны 63 жилийн ойн баяр наадмыг тохиолдуулан найруулагч Н.Баярцэнгэлийн найруулсан “Өнөд өвлөгдөх аялгуу” хүндэтгэлийн концертыг туурвихад 18,888,100 төгрөгийг зарцуулсан байна.

Энэхүү концертийг 2024 оны “Нүүдэлчин” дэлхийн соёлын фестивальд богиносгосон хэлбэрээр, Ахмадын баярын өдрийг тохиолдуулан тус тус үзэгчдийн хүртээл болгожээ.

6.1.2. Байгууллагын үйл ажиллагааг дэмжих зориулалт бүхий хөрөнгө оруулалтад 40% буюу 25,184.100 төгрөгийг зарцуулж, хөгжмийн зэмсэг 1 ширхэг /их хуур хөгжим/, 85 инчийн ухаалаг дэлгэц 1 ширхэг, А3 өнгөт принтер 1 ширхэг, зөөврийн компьютер /I7/ 1 ширхэг буюу нийт 4 нэр төрлийн 4 ширхэг техник хэрэслийг 25,1 сая төгрөгөөр худалдан авсан байна.

6.1.3. Албан хаагчдын нийгмийн асуудлыг шийдвэрлэх хүрээнд 15% буюу 9,444,000 төгрөгийг ажил олгогчоос олгох тэтгэмж урамшуулал зардлын ангиллаар 7 ангийн 11 албан хаагчдад буцалтгүй тусламж үзүүлжээ. 1 албан хаагчид дунджаар 674,571.75-1,349,142.00 төгрөг хүртэл олгосон байна. Үүнд:

Инженер, техникийн ангийн 1, дуу ангийн 2, бүжиг ангийн 1, драм ангийн 1, хөгжим ангийн 2, зохион байгуулах албаны 2, Захиргаа, аж ахуйн 2 албан хаагч тус тус хамрагджээ.

6.1.4. Ажилтны ажлын үр дүнг үнэлж, цалин урамшуулал олгосон санхүүжилтэд 15% буюу 9,444,000 төгрөгийг ажилтан, албан хаагчдын 2023 оны гүйцэтгэлийн тайланг үндэслэн тодорхой шалгуураар дүгнэж, зарцуулах саналыг хамт олны хурлаар хэлэлцэн нийт 88 албан хаагчдад олгосон байна.

Урамшууллаас нийгмийн даатгалын шимтгэл, хувь хүний орлогын албан татварыг холбогдох хууль, журмын дагуу суутгажээ.

Албан хаагчдын нийгмийн асуудлыг шийдвэрлэх хүрээнд олгосон урамшуулалд 2023 онд ажиллаж байгаагүй 2024 оны 03 дугаар сарын 01-ний өдрийн

Б/16 дугаар тушаалаар түр хугацаагаар томилогдсон хөгжимчин буюу морин хуурч Б.Энхсайханд 674,571.75 төгрөгийг олгосон.

Аж ахуй эрхэлсэн орлогч дарга Д.Эрдэнэцогтод 2022, 2023 оны үр дүнд суурилсан нэмэлт санхүүжилтээс ажилтны нийгмийн асуудлыг нь шийдвэрлэх хүрээнд 2 жил дараалан тэтгэмж олгосон байна.

Залуучууд театрын 2023 оны үйл ажиллагааны үр дүнгээр олгосон нэмэлт санхүүжилтийг 2023 оны 10 дугаар сарын байдлаар бүрэн зарцуулж дууссан бөгөөд санхүүгийн анхан шатны баримт, бараа материалын тайланг бүрэн бүрдүүлсэн байна.

6.2. Хүүхдийн номын ордон нь 2023 оны гүйцэтгэлийн үнэлгээгээр улсад 19 дүгээр байранд орж, **15,913,223.55** төгрөгийн санхүүжилт авсан байна. Журамд заасны дагуу нэмэлт санхүүжилтийн зарцуулалтыг дараах байдлаар төлөвлөж зарцуулжээ. Үүнд:

6.2.1. Хөтөлбөр, арга хэмжээ буюу уран бүтээл хийх, эрдэм шинжилгээний судалгааны ажлын зардалд 30% буюу 4,774,000 төгрөгийг Соёлын сайд, Боловсрол, Шинжлэх ухааны сайд, Хөдөлмөр нийгмийн хамгааллын сайд, Харилцаа холбооны сайдын хамтарсан 2023 оны А/152, А/195, А/57, А/40 дүгээр тушаалаар баталсан “Мэргэжлийн сургалтын байгууллагад тавих шаардлага”-ын хэрэгжилтийг хангах зорилгоор хүүхэд, багачуудад номын сангийн үйлчилгээгээр дамжуулан соёлын боловсрол олгох хөтөлбөрүүдийг боловсруулж, олон нийтэд сурталчлах, ном унших дадлыг сургах, оюунлаг иргэн болж төлөвшихөд нөлөөлөх соёл олон нийтийн ажилд тус тус зарцуулжээ. Тухайлбал:

➤ Үндэсний уламжлалт өв соёл болох гар урлалыг хадгалан авч үлдэх, түгээн дэлгэрүүлэх, сурталчлан таниулах зорилгоор “ЭСГИЙ ОЛБОГ” оёх сургалтыг зохион байгуулах удирдамж, төлөвлөгөө, төслийг боловсруулан батлуулж, **1,000,000** төгрөгийн өртөг бүхий мини эсгий олбогний бэлдэц, утас, зүү, даавуу, ном, хуруувч худалдан авч, нүүдлийн номын сангаар үйлчлүүлэгч хүүхэд багачууд болон тус ордноор үйлчлүүлэгч уншигчдын дунд нийт 3 удаа зохион байгуулж, 32 хүүхдийг хамруулсан байна. Цаашид тус сургалтыг 9 удаа зохион байгуулж, 90 хүүхдийг хамруулах төлөвлөгөөтэй ажиллаж байна.

➤ Нийт 13 арга хэмжээ зохион байгуулахаар төлөвлөснөөс 10 арга хэмжээг зохион байгуулж, 925 уншигч, хүүхэд багачуудыг хамруулж, 2024 оны 10 дугаар сарын байдлаар **2,860,000** төгрөг зарцуулжээ. **Үлдэгдэл 1,914,000** төгрөгийг 2024 оны 12 дугаар сард зохион байгуулагдах /Найргийн даага, Дүрийн тоглолт, Уран жиргээ/ арга хэмжээнүүдэд зарцуулахаар төлөвлөсөн байна.

6.2.2. Байгууллагын үйл ажиллагааг дэмжих зориулалт бүхий хөрөнгө оруулалтад 40% буюу 6,365,300 төгрөгийг зарцуулсан байна. Үүнээс:

➤ Хүүхдийн номын ордны үйл ажиллагааг олон нийтэд сурталчлах, сан хөмрөгийн номын мэдээллийг хэрэглэгчдэд нээлттэй хүргэх, электрон каталогийн ашиглалтыг сайжруулах зорилгоор киоск машиныг 1,648,900 төгрөгөөр худалдан авч, 1-р давхарт нийтэд ил байрлуулан ашиглаж байна.

➤ Байгууллагын хэвийн үйл ажиллагааг хангах, уншигч хүүхэд багачуудын сурч боловсрох, ажилтан албан хаагчдын ажиллах орчин нөхцлийг сайжруулах зорилгоор дулааны удирдлагын контеллёр 4,716,400 төгрөгөөр худалдан авч сольж суурилуулсан.

6.2.3. Албан хаагчдын нийгмийн асуудлыг шийдвэрлэх хүрээнд 15% буюу 2,387,000 төгрөгийг албан хаагчдын нийгмийн баталгааг хангахад зарцуулсан байна.

➤ “Ажилтан, албан хаагчдын нийгмийн баталгааг хангах чиглэлээр 2024 онд хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөө”-нд тусгагдсан 2 арга хэмжээний хэрэгжилтийг хангах хүрээнд ажилтан, албан хаагчдын дархлаажуулалтыг дэмжих, витаминжуулах үйл ажиллагаанд 738,000 төгрөг, соёл, олон нийтийн арга хэмжээнд зориулсан ажлын хувцас хийлгэхэд нийт 17 албан хаагчдад 1,649,000 төгрөг тус тус зарцуулсан байна.

6.2.4. Ажилтны ажлын үр дүнг үнэлж, цалин урамшуулал олгосон санхүүжилтэд 15% буюу 2,107,300 төгрөгийг ажилтан, албан хаагчдын 2023 оны ажлын үр дүнг дүгнэх журам, үзүүлэлтийн дагуу хүний нөөцийн хөгжил буюу мэдлэг мэргэжлээ дээшлүүлсэн байдал, санхүүгийн тайлангийн дүгнэлт, орлого төвлөрүүлэлт, нийтийг хамарсан уралдаан тэмцээн, арга хэмжээ, хурал цуглааны ирц, оролцоо, шинэ санал санаачилга, ёс зүй, харилцаа, хандлага, ажилласан хугацаа зэрэг шалгуураар дүгнэж, хамт олны хурлаар хэлэлцүүлэн 17 албан хаагчдад 8-12 хувиар үнэлж, 2,387,000 төгрөгийн урамшуулал олгосон байна.

Урамшууллаас нийгмийн даатгалын шимтгэл, хувь хүний орлогын албан татварыг холбогдох хууль, журмын дагуу суутгасан байна.

6.3. Музей нь нь 2023 оны гүйцэтгэлийн үнэлгээгээр улсад 18 дүгээр байранд орж, 16,636,679.93 төгрөгийн санхүүжилт авсан байна. Үр дүнд суурилсан нэмэлт санхүүжилтийн зарцуулалтыг зардал бүрээр нь дурдвал:

6.3.1. Хөтөлбөр, арга хэмжээ буюу уран бүтээл хийх, эрдэм шинжилгээний судалгааны ажлын зардалд 30% буюу 4,990,979 төгрөг хуваарилагдсан.

Эрдэмтэн, судлаачдын дунд зохион байгуулагдсан “Дарханы түүх соёл: Эрт эдүгээ” эрдэм шинжилгээний хурлын эмхтгэл хэвлүүлэхээр 2,632,500 төгрөг, ISBN-код авахад 18,000 төгрөг, Оюутны эрдэм шинжилгээний хурал зохион байгуулах зардалд 1,610,019 төгрөг, “Аж үйлдвэрийн Дархан-Бидний түүх” гэрэл зургийн үзэсгэлэнд зориулсан даавуун хэвлэлд 730,460 төгрөгийг тус тус зарцуулахаар төлөвлөжээ. 2024 оны 11 дүгээр сард дээрх 3 арга хэмжээг зохион байгуулж дуусгахаар ажиллаж байна.

6.3.2. Байгууллагын үйл ажиллагааг дэмжих зориулалт бүхий хөрөнгө оруулалтад 40% буюу 6,654,700 төгрөгийг Музейн үйл ажиллагааг олон нийтэд сурталчлах, баримтжуулах, архивын баялаг дижитал сан хөмрөг үүсгэх, албан хаагчдыг ажиллах нөхцлөөр хангах зорилгоор “nanoe” аргаар цэвэршүүлэгч 1 ширхэгийг 1,099,900 төгрөгөөр, киоск машин /32 инч/ 1 ширхэгийг 2,530,000 төгрөгөөр, термометр UNI-T A13T багаж 5 ширхэгийг 241,000 төгрөгөөр, Garmin GPS Map 276 CX багаж 1 ширхэгийг 2,600,000 төгрөгөөр, архивын үдэгч машин 1 ширхэгийг 183.000 төгрөгөөр тус тус худалдан авч үндсэн хөрөнгөдөө бүртгэсэн байна.

6.3.3. Албан хаагчдын нийгмийн асуудлыг шийдвэрлэх хүрээнд 15% буюу 2,495,500 төгрөгийг хамт олны хурлаар санал солилцон 8 албан хаагчийн нийгмийн асуудлыг шийдвэрлэхэд зарцуулсан байна.

6.3.4. Ажилтны ажлын үр дүнг үнэлж, цалин урамшуулал олгосон санхүүжилтийн хүрээнд 15% буюу 2,495,500 төгрөгийг ажилтан, албан хаагчдын 2023 оны гүйцэтгэлийн тайланг үндэслэн тодорхой шалгуураар дүгнэж, хамт олны хурлаар хэлэлцэн 8 албан хаагчдад олгосон байна.

Урамшууллаас нийгмийн даатгалын шимтгэл, хувь хүний орлогын албан татварыг холбогдох хууль, журмын дагуу суутгасан байна.

Үр дүнгийн санхүүжилтээр олгосон урамшууллыг 2023 оны жилийн эцсийн тайлан болон хамт олны хурлын тэмдэглэлийн хамт санхүүгийн баримтад хавсаргасан байна.

Өмнөх дотоод хяналт шалгалтаар өгсөн зөвлөмжийн дагуу албан хаагчдын ажлын үр дүнг үнэлэх журмыг боловсруулан баталж, байгууллагын албан хаагчдын 2023 оны ажлын үр дүнг бодитой үнэлэн урамшууллыг олгосон байна.

6.4. Төв номын сан нь 2023 оны гүйцэтгэлийн үнэлгээгээр улсад 9 дүгээр байранд үнэлэгдэн 22,700,672 төгрөгийн санхүүжилт авсан байна. Журамд заасны дагуу нэмэлт санхүүжилтийн зарцуулалтыг дараах байдлаар зарцуулжээ. Үүнд:

6.4.1. Хөтөлбөр, арга хэмжээ буюу уран бүтээл хийх, эрдэм шинжилгээний судалгааны ажлын зардалд 30% буюу 6,810,200 төгрөгийг уран бүтээл хийх, эрдэм шинжилгээ судалгааны ажил буюу "Номын сан-60" арга хэмжээний жилийн төлөвлөгөөнд орсон нэн шаардлагтай 2 багц ажлыг санхүүжүүлэн тайланг бэлтгэн гаргасан байна. Үүнд:

- "Дархан-Уул аймаг Төв номын сан" өнгөт ном хэвлүүлэх зардалд 4,500,000 төгрөг
- Бичиг хэрэг болон эсгий тор хэвлүүлэх зардалд 2,310,200 төгрөг тус тус зарцуулсан байна.

6.4.2. Байгууллагын үйл ажиллагааг дэмжих зориулалт бүхий хөрөнгө оруулалтад 40% буюу 9,080,300 төгрөгийг байгууллагын үйл ажиллагааг олон нийтэд сурталчлах, боловсролын хөтөлбөр хэрэгжүүлэх, албан хаагчдын ажиллах нөхцөлийг сайжруулах зорилгоор 1 ширхэг гурван үйлдэлт өнгөт принтер, 2 ширхэг иж бүрэн суурин компьютерийг шууд худалдан авалтаар авч, Сан хөмрөгч, нярав, Арга зүйч, Архив бичиг хэргийн ажилтан нарт хуваарилан өгч, ажлын бүтээмжийг нь дээшлүүлсэн байна.

6.4.3. Албан хаагчдын нийгмийн асуудлыг шийдвэрлэх хүрээнд 15% буюу 3,405,100 төгрөгийг 15 албан хаагчийн нийгмийн асуудлыг шийдвэрлэхэд зарцуулсан байна.

6.4.4. Ажилтны ажлын үр дүнг үнэлж, цалин урамшуулал олгосон санхүүжилтийн хүрээнд 15% буюу 3,405,100 төгрөгийг ажилтан, албан хаагчдын 2023 оны гүйцэтгэлийн тайланг үндэслэн тодорхой шалгуураар дүгнэж, ажлын үр дүнг нь хамт олны хурлаар хэлэлцүүлэн 15 албан хаагчдад олгохоор шийдвэрлэсэн байна.

Урамшууллаас нийгмийн даатгалын шимтгэл, хувь хүний орлогын албан татварыг холбогдох хууль, журмын дагуу суутгасан байна.

Өмнөх дотоод хяналт шалгалтаар өгсөн зөвлөмжийн дагуу албан хаагчдын ажлын үр дүнг үнэлэх журмыг боловсруулан баталж, байгууллагын албан хаагчдын 2023 оны ажлын үр дүнг бодитой үнэлэн урамшууллыг олгосон байна.

2023 оны үр дүнгээр олгосон нэмэлт санхүүжилтийг журмын дагуу бүрэн зарцуулсан байна.

6.5. Орхон сумын Соёлын төв нь улсын хэмжээнд 13 дугаар байранд орж 13,146,800 төгрөгийн нэмэлт санхүүжилт авсан байна. Зарцуулалтыг зардал тус бүрээр нь дурдвал:

6.5.1. Хөтөлбөр, арга хэмжээ буюу уран бүтээл хийх, эрдэм шинжилгээний судалгааны ажлын зардалд 30% буюу 3,944,040 төгрөгийг “Соёлын бүтээлч сар” аяны хүрээнд урлагаар дамжуулан хүүхэд багачуудын хүмүүжилд эерэг нөлөө үзүүлэх, нийгэмд зөв үлгэр дуурайллыг бий болгох, хөдөө орон нутагт тоглогдоод байдаггүй уран бүтээлийг сумын хүүхэд, багачуудад хүргэхээр Зохиолч В.Хауфын “ТОМ ХАМАРТ ОДОЙ” хүүхэлдэйн жүжгийн бэлтгэл сургуулилтад хамрагдах, жүжгийн гэрэлтүүлэг зэрэг материаллаг зүйлд зарцуулахаар төлөвлөжээ. 2024 оны 12 дугаар сард тоглогдохоор бэлтгэл ажлыг ханган ажиллаж байна

6.5.2. Байгууллагын үйл ажиллагааг дэмжих зориулалт бүхий хөрөнгө оруулалтад 40% буюу 5,258,700 төгрөгийг NIKON Z50 маркийн видео камер авахад зарцуулсан байна. Ингэснээр соёлын төвийн үйл ажиллагаа, арга хэмжээг цахимаар олон нийтэд хүргэх, видео контент хийх, улмаар ардын авьяастан, СББӨ-ийг өвлөн уламжлагчдыг олон нийтэд алдаршуулах боломжийг бүрдүүлжээ. .

6.5.3. Албан хаагчдын нийгмийн асуудлыг шийдвэрлэх хүрээнд 15% буюу 1,972,000 төгрөгийг 2023 онд ажиллаж 3 албан хаагчдад олгосон байна.

6.5.4. Ажилтны ажлын үр дүнг үнэлж, цалин урамшуулал олгосон санхүүжилтийн хүрээнд 15% буюу 1,972,020 төгрөгийг 2023 онд ажиллаж байсан техникч, музейн ажилтан, жижүүр нарт олгосон байна.

Урамшууллаас нийгмийн даатгалын шимтгэл, хувь хүний орлогын албан татварыг холбогдох хууль, журмын дагуу суутгасан байна.

Нягтлан бодох бүртгэлийн анхан шатны баримт бүрдүүлэлт бүрэн хийгдсэн, хамт олны хурлын тэмдэглэлийг санхүүгийн баримтад хавсаргасан байна.

Өмнөх дотоод хяналт шалгалтаар албан хаагчдад урамшуулал олгохдоо ажлын үр дүнг үнэлж, үнэлгээний журамд заасан шалгуур үзүүлэлтийн дагуу үнэлж, урамшууллыг тэгшитгэн хуваарилж олгохгүй байх талаар арга зүйн зөвлөмж өгсөн боловч хэрэгжүүлээгүй байна.

6.6. Шарын гол сумын Соёлын төв нь улсын хэмжээнд 1 дүгээр байранд орж 42,611,325.94 төгрөгийн нэмэлт санхүүжилт авсан байна. Санхүүжилтийн зарцуулалтыг аргачлалд заасны дагуу төлөвлөн зарцуулсан байдлыг дурдвал:

6.6.1. Хөтөлбөр, арга хэмжээ буюу уран бүтээл хийх, эрдэм шинжилгээний судалгааны ажлын зардалд 30% буюу 12,783,400 төгрөгийг зарцуулжээ. Үүнд:

➤ МУЗГ-ын үйл ажиллагааны хөтөлбөр-Нэгдүгээрт хүүхэд, Соёлын яам-Хөшиг нээгдэх бүрт- Хүргэх нэг үг, Дархан-Уул аймгийн Засаг даргын үйл

ажиллагааны хөтөлбөр-Хүүхдэд ээлтэй жил болгон зарласан зэрэг хөтөлбөр арга хэмжээний хүрээнд “Бяцхан мисс-2024”, “Авьяаслаг гэр бүл” тоглолтыг зохион байгуулж, хүүхэд багачуудын авьяас билгийг нээн илрүүлэх, Шарын гол сумын авьяаслаг гэр бүлийг олонд танин мэдүүлэх зорилгоор тоглолт зохион байгуулж 8,837,500 төсөв зарцуулж, үлдэгдэл 3,945,900 төгрөгийг “Соёлын бүтээлч сар 2024” аяны арга хэмжээнд зарцуулах төлөвлөгөөтэй ажиллаж байна.

6.6.2. Байгууллагын үйл ажиллагааг дэмжих зориулалт бүхий хөрөнгө оруулалтад 40% буюу 17,044,500 төгрөгийг байгууллагын үйл ажиллагааг өргөжүүлэх, соёлын хүртээмжийг нэмэгдүүлэх зорилтын хүрээнд иж бүрэн зөөврийн тайз карказ худалдан авахад зарцуулсан байна.

6.6.3. Албан хаагчдын нийгмийн асуудлыг шийдвэрлэх хүрээнд 15% буюу 6,391,700 төгрөгнөөс 3,091,700 төгрөгийг 7 ажилтан, албан хаагчдыг 45 хоногийн сургалтад зайн болон танхимаар хамруулахад зарцуулсан байна. 1 албан хаагчид 200,000 төгрөгний буцалтгүй тусламж үзүүлсэн.

Үлдэгдэл 3,100,000 төгрөгийг 2024 оны 11, 12 дугаар сард багтаан албан хаагчдыг эрүүл мэндийн үзлэг оношилгоонд хамруулах төлөвлөгөөтэй ажиллаж байна.

6.6.4. Ажилтны ажлын үр дүнг үнэлж, цалин урамшуулал олгосон санхүүжилтийн хүрээнд 15% буюу 6,391,700 төгрөгийг 6 албан хаагчид урамшуулал хэлбэрээр олгох асуудлыг хамт олны хурлаар хэлэлцэн шийдвэрлэж олгосон байна.

Урамшууллаас нийгмийн даатгалын шимтгэл, хувь хүний орлогын албан татварыг холбогдох хууль, журмын дагуу суутгасан байна.

Тус соёлын төв нь 2023 оны үйл ажиллагааны үр дүнгээр олгосон нэмэлт санхүүжилтийг аргачлалын дагуу зарцуулсан ба анхан шатны баримт бүрэн, бараа материалын тайланг санхүүгийн баримтад хавсаргасан байна.

Өмнөх дотоод хяналт шалгалтаар албан хаагчдад урамшуулал олгохдоо ажлын үр дүнг үнэлж, үнэлгээний журамд заасан шалгуур үзүүлэлтийн дагуу бодитоор үнэлэх, урамшууллыг тэгшитгэн хуваарилж олгохгүй байх талаар өгсөн зөвлөмжийн биелэлтийг хангаж ажиллаагүй байна.

6.7. Хонгор сумын Соёлын төв нь 2023 оны гүйцэтгэлийн үнэлгээгээр улсад 13 дугаар байр эзэлж, 12,953,076.42 төгрөгийн санхүүжилт авсан байна. Үр дүнд суурилсан нэмэлт санхүүжилтийн зарцуулалтын байдлыг дурдвал:

6.7.1. Хөтөлбөр, арга хэмжээ буюу уран бүтээл хийх, эрдэм шинжилгээний судалгааны ажлын зардалд 30% буюу 3,885,900 төгрөгийг сумын

65 жилийн ой, Үндэсний их баяр наадмын нээлт болон хаалтын үйл ажиллагаанд 3,100,000 төгрөг, жил бүр уламжлал болгон тоглогддог “Алтан намар” өвөл цагийн нээлтийн тоглолтод 400,000 төгрөг, Соёл урлагийн ажилтны баярыг тохиолдуулан зохион байгуулах соёлын олон талт үйл ажиллагаанд 385,000 төгрөгийг тус тус төлөвлөн зарцуулсан байна.

6.7.2. Байгууллагын үйл ажиллагааг дэмжих зориулалт бүхий хөрөнгө оруулалтад 40% буюу 5,181,200 төгрөгийг зарцуулжээ. Үүнд:

Байгууллагын засвар үйлчилгээ, аж ахуйн ажлыг хийх, урлагийн үйл ажиллагааг нүүдлээр хүргэхэд нэн шаардлагатай цахилгаан үүсгэвэр, А шат, давхар шат, засварын ком багаж хэрэгсэл зэрэг тоног төхөөрөмж худалдан авахад 5,210,000 төгрөгөөр худалдан авсан бөгөөд зөрүү 28,800.00 төгрөгийг үндсэн зардлаас гаргасан байна.

6.7.3. Албан хаагчдын нийгмийн асуудлыг шийдвэрлэх хүрээнд 15% буюу 1,943,000 төгрөгийг зарцуулжээ. Үүнд:

➤ Гэр хороололд амьдардаг 1 албан хаагчид түлээ, мод авахад нь 593,000 төгрөгийн тусламж үзүүлсэн.

➤ Албан хаагчдыг эрүүл мэндийн урьдчилан сэргийлэх багц үзлэгт хамруулахад 1,350,000 төгрөгийг зарцуулахаар төлөвлөсөн. Нэгдсэн эмнэлэгтэй гэрээ байгуулж, үзлэгт орох өдрөө товлосон байдалтай байна.

6.7.4. Ажилтны ажлын үр дүнг үнэлж, цалин урамшуулал олгосон санхүүжилтийн хүрээнд 15% буюу 1,943,000 төгрөгийг 7 ажилтан, албан хаагчдын урамшуулалд зориулж, бусдыгаа манлайлж ажилласан хөгжмийн багшид 500,000 төгрөгийг олгож, 1,443,000 төгрөгийг 5 албан хаагчдад ижил тэнцүү хуваан олгохоор хамт олны хурлаар хэлэлцүүлэн харилцан ярилцаж шийдвэрлэсэн байна.

Урамшууллаас нийгмийн даатгалын шимтгэл, хувь хүний орлогын албан татварыг холбогдох хууль, журмын дагуу суутгасан байна.

Нягтлан бодох бүртгэлийн анхан шатны баримт бүрдүүлэлт бүрэн хийгдсэн, хурлын тэмдэглэлийг санхүүгийн баримтад хавсаргасан байна.

Өмнөх дотоод хяналт шалгалтаар албан хаагчдад урамшуулал олгохдоо ажлын үр дүнг үнэлгээний журамд заасан шалгуур үзүүлэлтийн дагуу үнэлэх, албан хаагчдад олгох урамшууллыг тэгшитгэн хуваарилж олгохгүй байх талаар арга зүйн зөвлөмж өгсөн боловч хэрэгжүүлээгүй байна.

Долоо. Шалгуулагчийн ололттой, дэвшилттэй тал:

7.1. Харьяа соёлын 7 байгууллага нь 2023 оны үйл ажиллагааны үр дүнгээр олгосон нэмэлт санхүүжилтийг аргачлалын дагуу зөрчилгүй зарцуулсан байна.

7.2. Харьяа байгууллагуудын Нягтлан бодох бүртгэлийн анхан шатны баримт бүрэн, бараа материалын тайланг иж бүрэн бэлтгэсэн байна.

7.3. Музей нь байгууллагын үйл ажиллагааг дэмжих зориулалт бүхий хөрөнгө оруулалтад нэмэлт санхүүжилтийн 40% буюу **6,654,700** төгрөгийг байгууллагын үйл ажиллагааг олон нийтэд сурталчлах, баримтжуулах, архивын баялаг дижитал сан хөмрөг үүсгэх, албан хаагчдыг ажиллах нөхцлөөр хангах зорилгоор “napoe” аргаар цэвэршүүлэгч 1 ширхэг, **киоск 32 инч 1 ширхэг**, термометр /UNI-T A13T/ багаж 5 ширхэг, уртраг, өргөрөг хэмжих багаж /GARMIN GPS Map 276 CX/ 1 ширхэг (уг GPS-ыг өөр байгууллагаас түрээсээр авч хэрэглэдэг байсан), архивын үдэгч машин 1 ширхэгийг тус тус худалдан авч үндсэн хөрөнгөнд бүртгэсэн байна. Хөрөнгө оруулалт хийснээр музейн үзвэр, үйлчилгээг үзэгчдэд хүргэх соёлын үйлчилгээ сайжирч илүү боловсронгуй болж, ажлын бүтээмж, цаг ашиглалт, ажиллах эрч хүч, урам зориг нэмэгдэж, ажилчдын эрүүл мэнд, ажиллах орчин нөхцөл сайжирсан гэж албан хаагчид үнэлж байна.

7.4. Музей нь эрдэм шинжилгээний судалгааны ажилд нэмэлт санхүүжилтийн 30% буюу **1,610,019** төгрөгийг эрдэмтэн, судлаачдын дунд зохион байгуулагдсан “Дарханы түүх соёл: Эрт эдүгээ” эрдэм шинжилгээнэий хурлын эмхтгэл хэвлүүлэх, Оюутны эрдэм шинжилгээний хурал зохион байгуулах зардалд зарцуулсан байна.

7.5. Орхон сумын Соёлын төв нь нэмэлт санхүүжилтийн 30% буюу **3,944,040** төгрөгийг уран бүтээл хийх чиглэлээр “Соёлын бүтээлч сар” аяны хүрээнд орон нутгийн Соёлын төвд урлагаар дамжуулан хүүхэд багачуудын хүмүүжилд эерэг нөлөө үзүүлэх, нийгэмд зөв үлгэр дуурайллыг бий болгох, хөдөө орон нутагт тоглогдоод байдаггүй уран бүтээлийг сум орон нутгийн хүүхэд багачуудад хүргэхээр Зохиолч В.Хауфын “ТОМ ХАМАРТ ОДОЙ” хүүхэлдэйн жүжгийн бэлтгэл сургуулилтад хамрагдах, жүжгийн гэрэлтүүлэг зэрэг материаллаг зүйлд зарцуулан ажилласан байна.

Найм. Дотоод хяналтаар илрүүлсэн зөрчил, дутагдал, шалтгаан

8.1. Харьяа соёлын 7 байгууллага болох Залуучууд театр, Музей, Төв номын сан, Хүүхдийн номын ордон, Орхон, Хонгор, Шарын гол сумдын Соёлын төвүүдэд 2023 оны үйл ажиллагааны үр дүнгээр олгосон нэмэлт санхүүжилтийн зарцуулалтад 2024 оны 10 дугаар сарын байдлаар дотоод хяналт хийж, хэрэгжилтэд хяналт

тавихад илэрсэн зөрчилгүй, нэмэлт санхүүжилтийг холбогдох журмын дагуу зарцуулсан хэдий ч ажилтан, албан хаагчдын нийгмийн асуудлыг шийдвэрлэх хүрээнд олгосон урамшууллын хувьд Залуучууд театр нь 2023 онд ажиллаагүй 1 хөгжимчинд 674,571.75 төгрөгийг олгосон нь ССАЖЗ-ын сайдын 2023 оны 10 дугаар сарын 09-ны өдрийн А/390 дугаар тушаалаар баталсан "Соёлын байгууллагуудын үр дүнд суурилсан санхүүжилтийн аргачлал"-ын 7.2 дахь заалтыг зөрчсөн байна.

Аж ахуй эрхэлсэн орлогч дарга Д.Эрдэнэцогтод 2022, 2023 оны үр дүнд суурилсан нэмэлт санхүүжилтээс нийгмийн асуудлыг шийдвэрлэх хүрээнд 2 жил дараалан тэтгэмж олгосон байна.

**Ес. Дотоод аудитын явцад авсан арга хэмжээ,
мэргэжлийн туслалцаа, зөвлөгөө өгсөн байдал:**

9.1. ССАЖЗЯ-наас олгосон 2023 оны үр дүнд суурилсан нэмэлт санхүүжилтийг зарцуулахдаа санхүүгийн төлөвлөгөөг урьдчилан боловсруулж, ажилтан, албан хаагч нараас санал авч хамт олны хурлаар хэлэлцүүлсэн байх;

9.2. Ажиллагсдын нийгмийн асуудлыг шийдвэрлэх хүрээнд тэтгэмж олгохдоо 1 ажилтанд жил дараалан олгохгүй байхад анхаарч, тусламж дэмжлэг нэн шаардлагатай бусад ажилтан, албан хаагчдад боломж олгох;

9.3. Ажилтан, албан хаагчдын ажлын үр дүнг үнэлж, цалин урамшуулал олгох хүрээнд зарцуулалтыг хийхдээ ажилтны ажлын үр дүнг үнэлэх дүгнэх журмыг боловсруулан батлуулж, шалгуур үзүүлэлтийг үндэслэн ажлын үр дүнг бодитоор үнэлж, урамшуулал олгож байх зэрэг асуудлаар хууль эрх зүйн туслалцаа үзүүлж, мэргэжил арга зүйн зөвлөгөө өгч ажиллалаа.

**Арав. Шалгуулагч этгээдэд өгсөн дүгнэлт,
шийдвэрлэвэл зохих асуудал:**

10.1. Соёлын сайдын 2023 оны А/390 дүгээр тушаалаар баталсан "Соёлын байгууллагуудын үр дүнд суурилсан санхүүжилтийн аргачлал"-ын дагуу 2023 оны үр дүнгийн нэмэлт санхүүжилтээр соёлын 7 байгууллагад нийтдээ 186,652,300 төгрөг орж ирснээс 2024 оны 10 дугаар сарын байдлаар 166,083,300 төгрөгийг зарцуулж, соёлын 5 байгууллага нь үлдэгдэл 20,569,000 төгрөгийн санхүүжилтийг 2024 оны 11, 12 дугаар сард зохион байгуулагдах 12 арга хэмжээнд зарцуулахаар төлөвлөсөн байна.

10.2. Соёлын байгууллагуудын үр дүнд суурилсан нэмэлт санхүүжилтийн аргачлалын хэрэгжилт дунджаар 95%-тай байна. Энэхүү аргачлалыг хэрэгжүүлснээр:

1-рт: Соёлын байгууллагуудад дотоод орлогоор санхүүжүүлэх боломжгүй хүлээгдэж байсан уран бүтээл болон эрдэм шинжилгээний ажил, боловсролын хөтөлбөрүүдийг хэрэгжүүлэх боломжтой болсон.

2-рт: Байгууллагын дотоод үйл ажиллагааг хэвийн явуулахад нэн шаардлагатай байсан техник хэрэгсэл, тоног төхөөрөмжийн шинэчлэлт хийгдсэн.

3-рт: Албан хаагчдын нийгмийн асуудлыг шийдвэрлэж, эрүүл мэндийн үзлэг оношилгоо, эрт илрүүлэгт хамруулсан.

4-рт: Ажилтан, албан хаагчид тухайн жилийнхээ ажлын үр дүнг үнэлүүлж, тодорхой хувиар урамшуулал авдаг болсон.

5-рт: Үр дүнд суурилсан нэмэлт санхүүжилтийн талаар хамт олны хурлаар хэлэлцэн зөвшилцөж, зарцуулалт хийдэг болсон.

6-рт: Үр дүнд суурилсан нэмэлт санхүүжилтийн үр нөлөө сайн гэж үнэлсэн.

7-рт: Үр дүнд суурилсан нэмэлт санхүүжилтийн зардлаар техник хэрэгсэл, тоног төхөөрөмж худалдан авч ажилтан, албан хаагчдын ажиллах нөхцөлийг сайжруулах боломж бүрдсэн.

8-рт: Үр дүнд суурилсан нэмэлт санхүүжилтээр ажилтан, албан хаагчдын нийгмийн асуудлыг шийдвэрлэхэд тодорхой үр дүнд хүрсэн, эрүүл мэндийн болон нэн шаардлагатай тусламж дэмжлэг үзүүлдэг болсон зэрэг эерэг үр дүнгүүд гарсан.

10.3. Үр дүнгийн нэмэлт санхүүжилтийг хөтөлбөр, арга хэмжээ буюу уран бүтээл хийх, эрдэм шинжилгээний судалгааны ажил, байгууллагын үйл ажиллагааг дэмжих зориулалт бүхий хөрөнгө оруулалт, албан хаагчдын нийгмийн асуудлыг шийдвэрлэх, ажилтны ажлын үр дүнг үнэлж цалин урамшуулал олгох гэсэн эрэмбэ, тогтсон хувь хэмжээгээр тооцон бүрэн зарцуулах тал дээр анхаарч ажиллах нь зүйтэй байна.

Арван нэг. Цаашид авах арга хэмжээний санал:

Харьяа соёлын байгууллагын удирдлагуудад:

11.1. 2024 оны үр дүнд суурилсан нэмэлт санхүүжилт олгогдохтой холбогдуулан соёлын байгууллагууд ямар чиглэлээр хөтөлбөр, арга хэмжээ буюу уран бүтээл хийх, хөрөнгө оруулалтыг татах, албан хаагчдын нийгмийн асуудал, цалин урамшууллын асуудлыг хэрхэн шийдвэрлэх талаар ажилтан, албан хаагч нараас санал авч, хамт олны хурлаар хэлэлцүүлж байх;

11.2. Сумдын соёлын төвүүд нь ажилтан, албан хаагчдын нийгмийн асуудлыг шийдвэрлэхэд шинэ санаачилга гаргах, хамт олны саналыг тусгах, дотоод хяналтаар өгсөн зөвлөмжийн хэрэгжилтийг хангаж ажиллах;

11.3. Ажилтан, албан хаагчдад урамшуулал олгохдоо ажлын үр дүнг үнэлэх журмыг дотооддоо боловсруулан батлуулах, мөрдөх;

11.4. Соёлын байгууллагууд урамшууллыг бүх ажилтан, албан хаагч нартаа тэгшитгэсэн байдлаар олгохгүй, шалгуур үзүүлэлтийн дагуу бодитой үнэлж урамшууллыг олгож байхад анхаарах;

11.5. Үр дүнгийн нэмэлт санхүүжилтийн зарцуулалтын талаарх саналыг хамт олны хурлаар хэлэлцүүлж, харилцан санал, бодлоо солилцон зөвшилцөж, хурлын тэмдэглэлийг санхүүгийн баримтад хавсаргаж хэвших;

11.6. Санхүүгийн сахилга батыг сахиж ажиллах.

ТАНИЛЦУУЛГА БИЧСЭН:

ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭ, СТАТИСТИК МЭДЭЭ

ХАРИУЦСАН МЭРГЭЖИЛТЭН, ДОТООД ХЯНАЛТ

ХАРИУЦСАН АЖИЛТАН

Ш.ДЭЛГЭРМАА

ТӨСӨВ, ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН АСУУДАЛ ХАРИУЦСАН

АХЛАХ МЭРГЭЖИЛТЭН

П.ЦОГЦЭЦЭГ